



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*


2020 оны 12 дугаар сар

Ерөнхий тойм: Энэ оны эхний 12 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6%-иар буюу 877 сая ам.доллараар буурч 12,870 сая ам.доллар байв. Үүнд экспорт 1%-иар буюу 43 сая ам.доллараар, импорт 14%-иар буюу 834 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 790 сая ам.доллараар өсч 2,282 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Жилээр			Эхний 12 сар			Өөрчлөлт	
	2017	2018	2019	2018	2019	2020	2020/2019	Дүн Хувь
Эргэлт	10,538	12,887	13,747	12,887	13,747	12,870	(877)	-6%
Экспорт	6,201	7,012	7,620	7,012	7,620	7,576	(43)	-1%
Импорт	4,337	5,875	6,128	5,875	6,128	5,294	(834)	-14%
Тэнцэл	1,863	1,137	1,492	1,137	1,492	2,282	790	53%

Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл нийт бараа эргэлтийн 57% буюу 7,383 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 11% буюу 1,457 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 19%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 16%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс:

2020 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 32%-иар, өмнөх сараас 3%-иар тус тус өсч 2.106-д хүрлээ.

Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс өсөхөд зэсийн баяжмал, чулуун нүүрс болон алтны экспортын үнэ өссөнөөр тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас өсөхөд зэс болон хэрэглээний барааны импортын үнийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт: 2020 оны эхний 12 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 1%-иар буюу 43 сая ам.доллараар буурав. Үүнд мал аж ахуй болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 1 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл, эхний 12 сар /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²
1. Уул уурхай		6,200	88%		6,751	89%		7,039	93%	289	4%	4%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,437	2,012	29%	1,404	1,796	24%	1,395	1,778	23%	(18)	-1%	0%
1.2. Чулуун нүүрс	35,758	2,786	40%	36,467	3,074	40%	28,587	2,124	28%	(951)	-31%	-12%
1.3. Боловсруулаагүй нефть	6,190	392	6%	6,545	367	5%	4,071	151	2%	(216)	-59%	-3%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	7,449	342	5%	8,449	576	8%	8,202	640	8%	63	11%	1%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,432	144	2%	9,069	418	5%	30,491	1,788	24%	1,369	327%	18%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	124	198	3%	135	189	2%	134	168	2%	(21)	-11%	0%
1.7. Жонош, лейцит, нефелинт	555	190	3%	699	206	3%	679	156	2%	(49)	-24%	-1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	6	50	1%	6	49	1%	6	41	1%	(8)	-17%	0%
1.9. Гянт болдын хүдэр, баяжмал	1	9	0%	1	7	0%	0	1	0%	(6)	-89%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	1	0%	0	-	0%	201,586	124	2%	124	0%	2%
1.11. Бусад	536	75	1%	156	69	1%	112	70	1%	1	1%	0%
2. Мал аж, ахуй	412	477	7%	312	481	6%	200	292	4%	(189)	-39%	-2%
2.1. Амьд мал, малын мах	41	87	1%	40	84	1%	21	41	1%	(43)	-51%	-1%
2.2. Арьс, шир	342	17	0%	244	13	0%	158	7	0%	(6)	-48%	0%
2.3. Малын өлөн гэдэс	1	9	0%	1	9	0%	1	9	0%	0	5%	0%
2.4. Ноолуур	9	333	5%	8	344	5%	9	220	3%	(125)	-36%	-2%
2.5. Ноос, бусад үс, хялгас	15	28	0%	17	28	0%	11	14	0%	(14)	-50%	0%
2.6. Бусад	4	3	0%	3	2	0%	0	1	0%	(1)	-51%	0%
3. Газар тариалан	56	15	0%	62	16	0%	46	14	0%	(2)	-13%	0%
4. Аж үйлдвэрлэл	234	319	5%	390	372	5%	206	230	3%	(141)	-38%	-2%
4.1. Хүнс	36	92	1%	23	59	1%	25	68	1%	9	15%	0%
4.2. Ноолууран эдлэл	1	35	0%	1	46	1%	1	33	0%	(12)	-27%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	4	25	0%	4	20	0%	5	16	0%	(4)	-20%	0%
4.4. Уул уурхай	61	107	2%	180	121	2%	26	70	1%	(51)	-42%	-1%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	3	0%	0	1	0%	0	1	0%	(0)	-16%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд	3	52	1%	4	118	2%	2	38	0%	(80)	-68%	-1%
4.7. Бусад	129	5	0%	179	7	0%	147	5	0%	(3)	-35%	0%
5. Бусад	1	1	0%	1	1	0%	0	1	0%	(0)	12%	0%
Нийт дүн		7,012		7,620			7,576			(43)	-1%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 12 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт
1. Уул уурхай	637		(348)		289
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(11)	61%	(7)	39%	(18)
1.2. Чулуун нүүрс	(585)	62%	(365)	38%	(951)
1.3. Боловсруулаагүй нефть	(92)	42%	(124)	58%	(216)
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(19)	-30%	83	130%	63
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	1,256	92%	113	8%	1,369
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(1)	4%	(20)	96%	(21)
1.7. Жонош, лейцит, нефелинт	(5)	10%	(44)	90%	(49)
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4	-52%	(13)	152%	(8)
1.11. Бусад	(28)	-2680%	29	2780%	1
2. Мал аж, ахуй	(41)	22%	(147)	78%	(189)
2.1. Амьд мал, малын мах	(37)	85%	(7)	15%	(43)
2.2. Арьс, шир	(4)	59%	(3)	41%	(6)
2.4. Ноолуур	16	-13%	(140)	113%	(125)
3. Газар тариалан	(5)	230%	3	-130%	(2)
4. Аж үйлдвэрлэл	(444)	314%	303	-214%	(141)
5. Бусад	(1)	-518%	0	55%	0
Нийт дүн	146		(190)		(43)

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2020 оны эхний 12 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс нийт 43 сая ам.долларын буурсныг тодруулбал:

1/ Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 637 сая ам.доллараар өсч, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 348 сая ам.доллараар буурсан.

2/ Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспорт биет хэмжээний бууралтаас шалтгаалж 41 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 147 сая ам.доллараар буурчээ.

- Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 12 дугаар сард 1,860 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 25%-иар өссөн бол өмнөх сараас 0.3%-иар буурсан.

- “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэсийн үнэ тайлант сард 7,772 ам.долларт хүрч, өмнөх оноос 28%-иар, өмнөх сараас 10%-иар өссөн.

- Төмрийн хүдрийн дундаж үнэ 155 ам.долларт хүрч, өмнөх оноос 68%-иар, өмнөх сараас 25%-иар өссөн.

- Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 12 дугаар сард 76 ам.долларт хүрч, өмнөх оноос 2%-иар буурсан бол өмнөх сараас 4%-иар өссөн байна.

Импорт: 2020 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14%-иар буюу 834 сая ам.доллараар буурав. Импортын 14 нэгж хувийн бууралтыг ерөнхий ангиллаар авч үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 1 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл, эхний сар /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		1,643	28%		1,631	27%		1,542	29%	(88)	-5%	-1%
Түргэн эдэлгээтэй	970	864	15%	913	859	14%	967	878	17%	19	2%	0%
Хүнс	463	596	10%	438	605	10%	452	613	12%	7	1%	0%
Эм, тариа	3	119	2%	3	109	2%	3	120	2%	11	10%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	504	149	3%	473	145	2%	512	146	3%	1	0%	0%
Удаан эдэлгээтэй	238	779	13%	298	772	13%	295	664	13%	(108)	-14%	-2%
Гутал, хувцас, цүнх	61	74	1%	64	68	1%	103	73	1%	5	7%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	99	120	2%	154	109	2%	108	107	2%	(3)	-2%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	2	499	9%	2	508	8%	1	384	7%	(123)	-24%	-2%
Бусад удаан эдэлгээтэй бараа	77	85	1%	78	86	1%	83	100	2%	13	16%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,458	2,396	41%	1,298	2,661	43%	1,471	2,285	43%	(376)	-14%	-6%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	31	1,512	26%	29	1,801	29%	37	1,414	27%	(387)	-21%	-6%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	442	8%	2	641	10%	9	486	9%	(156)	-24%	-3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	30	1,070	18%	26	1,159	19%	28	929	18%	(231)	-20%	-4%
Барилгын материал	780	648	11%	966	654	11%	1,249	599	11%	(54)	-8%	-1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	48	236	4%	47	206	3%	130	272	5%	65	32%	1%
Аж үйлдвэрлэлийн орц	1,576	717	12%	1,845	665	11%	1,863	634	12%	(30)	-5%	0%
Хүнсний орц	282	79	1%	54	25	0%	176	49	1%	24	94%	0%
Химийн бүтээгдэхүүн	207	122	2%	222	118	2%	200	110	2%	(8)	-6%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	83	32	1%	77	28	0%	71	23	0%	(4)	-16%	0%
Цахилгаан эрчим хүч	2	143	2%	2	144	2%	110	142	3%	(2)	-1%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	1	0%	1	1	0%	1	1	0%	(0)	-6%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалттай	884	341	6%	943	349	6%	913	309	6%	(40)	-11%	-1%
Нефтийн бүтээгдэхүүн	1,576	1,112	19%	1,845	1,166	19%	1,863	817	15%	(349)	-30%	-6%
Дизель түлш	849	577	10%	1,080	669	11%	1,027	432	8%	(237)	-35%	-4%
АИ-92, АИ-95	371	264	4%	476	289	5%	529	222	4%	(68)	-23%	-1%
А-80 болон бусад	356	272	5%	288	207	3%	307	163	3%	(44)	-21%	-1%
Бусад	15	7	0%	6	5	0%	250	15	0%	9	172%	0%
Нийт дүн		5,875		6,128				5,294		(834)	-14%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

2020 оны эхний 12 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт импорт 834 сая ам.доллараар буурсан. Үүнд:

- Машин, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн буюу механик тоног төхөөрөмжийн импорт 376 сая ам.доллараар,
- Дизель түлшний хэрэглээнээс хамаарч нефтийн бүтээгдэхүүний импорт 349 сая ам.доллараар,
- Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 88 сая ам.доллараар,
- Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 30 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 12 сар / сая ам.доллар/

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт
Хэрэглээний бүтээгдэхүүн	0	0%	(89)	100%	(88)
Хөрөнгө оруулалтын бүтээгдэх	510	-136%	(886)	236%	(376)
Аж үйлдвэрлэлийн орц	149		(179)		(30)
Нефтийн бүтээгдэхүүн	10	-3%	(358)	103%	(349)
Дизель түлш	(23)	10%	(214)	90%	(237)
АИ-92, АИ-95	22	-33%	(90)	133%	(68)
А-80 болон бусад	10	-23%	(54)	123%	(44)
Бусад	15		(5)		9
Нийт дүн	684	-82%	(1,517)	182%	(834)

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.